



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/09/НА-СТА-ААТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2021 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор Ж.Бүжинханд Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



“АЛТАЙ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ”
ААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.НАРАНЧИМЭГ
ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13.
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2022.02.15 № 114

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар гэрээнд заасан хуваарьт хугацаанд үндсэн төлбөр, алданги, түрээсийн төлбөрийг төлүүлээгүй, иргэдээс зогсоолын төлбөр, сууц эзэмшигчдийн хураамжийг дутуу төлүүлсэн, шүүхийн шийдвэрээр байгууллагад буцаан төлөхөөр тогтоогдсон тэмдэгтийн хураамжийг төлүүлээгүй, Хөгжлийн банканд хугацаа хэтэрсэн зээл, хүү, алдангийн үлдэгдэлтэй, бараа материалын тайлангүй, техник хяналтын болон зогсоолын түрээсийн орлогын төлөвлөгөөг тасалсан зэрэг 334.5 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

0702000266

Хөгжлийн банкт хийсэн гэрээний зээлийн эргэн төлөлтийн хуваарийг орон сууц эзэмшигчтэй хийсэн гэрээний эргэн төлөлтийн хуваарьтай харьцуулж үзэхэд өссөн дүнгээр 2021 онд 1,136.5 сая төгрөгийн, 2022 онд 2,336.9 сая төгрөгийн, 2023 онд 3,437.2 сая төгрөгийн, 2024 онд 4,456.3 сая төгрөгийн эх үүсвэр дутагдахаар тооцоотой байна.

Хөгжлийн банканд төлөх хуваарийг тогтоохдоо түрээслэгчээс авах жил бүрийн орлогын эх үүсвэрийг харгалзаж тооцоогүй, хүүг төлөх асуудлыг шийдвэрлээгүй, түрээслэгчээс төлсөн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн зэргээс шалтгаалж 2022 онд орон сууцны үндсэн төлбөрт 3,159.4 сая төгрөгийн, хүүд 198.0 сая төгрөгийн, алдангид 28.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 87.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	7,362,744.0	7,410,220.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	24,723.8	1,350,273.5
Нийт хөрөнгийн дүн	7,387,467.8	8,760,494.2
Нийт өр төлбөрийн дүн	7,187,687.8	7,132,754.1
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	199,780.0	1,627,740.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,387,467.8	8,760,494.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	165,391.2	1,564,017.9
Үйл ажиллагааны зардлын дүн	108,088.3	140,557.7
Үйл ажиллагааны үр дүн	57,302.9	1,423,460.1
Үйл ажиллагааны бус үр дүн	1,000.0	4,500.0
Үйл ажиллагааны нийт үр дүн	58,302.9	1,427,960.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		0.0
Өмчид гарсан өөрчлөлт	141,476.9	199,780.0
Тайлант оны үр дүн	647,946.0	683,452.4
Эцсийн үлдэгдэл	199,780.0	1,627,740.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	745,546.6	830,512.3
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	97,600.5	147,059.9
Үйл ажиллагааны ЦМГ	647,946.1	683,452.4
Хөрөнгө оруулалтын ЦМГ	32,281.4	-1,008,599.9
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	680,227.5	-325,147.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	405,750.3	1,085,977.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,085,977.7	760,830.2

Гурав. Аудитын илрүүлэлт:

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,431.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Авлагыг 1,249.7 сая төгрөгөө, борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгийг 19.5 сая төгрөгөөр, өглөгийг 128.9 сая төгрөгөөр, урьдчилж олсон орлогыг 4.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тайланд орлогыг 27.0 сая төгрөгөөр, цалин хөлсний татварын тайланд ажилчдын цалинг 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдаа гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 334.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 295.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 39.4 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 4 заалт албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Гэрээнд заасан хуваарьт хугацаанд 242.2 сая төгрөгийн үндсэн төлбөр, 14.4 сая төгрөгийн алданги, 12.7 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг төлүүлээгүй нь Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 133/ШШ2022/00514, 33/ШШ2022/00509, 33/ШШ2022/00515, 33/ШШ2022/00526, 33/ШШ2022/00512, 33/ШШ2022/00513, 33/ШШ2022/00511, 33/ШШ2022/00516 дугаар бүхий шүүгчийн захирамж, Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3.2-т "Гэрээний хавсралтад заасан төлбөр төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг 2 сар төлөөгүй тохиолдолд сануулах ба 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд түрээслээд өмчлөгчтэй байгуулсан гэрээг цуцалж энгийн түрээсээр тооцож хуримтлуулсан урьдчилгаанаас тооцож авна" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Иргэдээс зогсоолын төлбөр 0.5 сая төгрөгийг, сууц эзэмшигчдийн хураамж 1.7 сая төгрөгийг дутуу төлүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Шүүхийн шийдвэрээр байгууллагад буцаан төлөхөөр тогтоогдсон 2.0 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийг төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалт, Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 133/ШШ2022/00514, 33/ШШ2022/00509, 33/ШШ2022/00515, 33/ШШ2022/00526, 33/ШШ2022/00512, 33/ШШ2022/00513, 33/ШШ2022/00511, 33/ШШ2022/00516 дугаар бүхий шүүгчийн захирамжийг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Борлуулсан авто машины зогсоолын үнээс 21.5 сая төгрөгийг төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Албан шаардлага

- ✓ Хөгжлийн банканд төлөх хуваарийг тогтоохдоо түрээслэгчээс авах жил бүрийн орлогын эх үүсвэрийг харгалзаж тооцоогүй, хүүг төлөх асуудлыг шийдвэрлээгүй, түрээслэгчээс төлсөн төлбөрийг Хөгжлийн банканд дутуу төвлөрүүлсэн зэргээс шалтгаалж Хөгжлийн банкт хийсэн гэрээний дагуу 2019-2022 онд орон сууцны үндсэн төлбөрт 3,159.4 сая төгрөг, хүүд 198.0 сая төгрөг, алдангид 28.5 сая төгрөгийг төлөөгүй нь нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээний 2.3-т "Худалдан авагч зээлээр худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн үнийг Гэрээний Хавсралт 2-т тусгасан хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар тооцож, алданги ногдуулна" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Шүүгчийн захирамжаар баталсан эвлэрлийн хугацаа дууссан байхад төлбөрөө төлөөгүй 5 түрээслэгчийн авлагыг барагдуулах, эвлэрлийн гэрээнд заасан арга хэмжээ аваагүй нь Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 133/ШШ2022/00514, 33/ШШ2022/00509, 33/ШШ2022/00515, 33/ШШ2022/00526, 33/ШШ2022/00512, 33/ШШ2022/00513, 33/ШШ2022/00511, 33/ШШ2022/00516 дугаар бүхий шүүгчийн захирамжийг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тайлант хугацаанд бэлтгэсэн 5.7 сая төгрөгийн материалыг бараа материалын тайланд орлого зарлагаар тайлагналгүй шууд зардлаар тайлагнасан. Нярын тайлангүй, нягтлан бодогч үүргийг гүйцэтгэж байгаа нь хяналтын үйл ажиллагааг алдагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандарт;" 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах," гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч техник хяналтын орлогын төлөвлөгөөг 31.0 сая төгрөгөөр, зогсоолын түрээсийн орлогын төлөвлөгөөг 2.6 сая төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 108 дугаар тогтоолын хавсралтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
"Алтай орон сууцны	6	1,431.5	-	-	6	1,431.5	6	1,431.5	-	-	-	-

корпораци" ААТҮГ												
Дүн	6	1,431.5	-	-	6	1,431.5	6	1,431.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
"Алтай орон сууцны корпораци" ААТҮГ	8	334.5	4	295.1	4	39.4	-	-				
Дүн	8	334.5	4	295.1	4	39.4	-	-			-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-